



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 5/269

Улаанбаатар хот

Бүгд Найрамдах Хятад Ард Улсад
албан томилолтоор ажиллуулах
тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүү, аж ахуйн албаны Хангамжийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Сангидоржийн Баасанжав, мөн хэлтсийн хувцасны ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Гаваагийн Баялагмаа нарыг цагдаагийн алба хаагчдын 2018 оны хэрэгцээт дүрэмт хувцасны үндсэн болон туслах материал, мөрдөс, ялгах тэмдгийг бэлтгэн нийлүүлэх үйлдвэрийн судалгааг хийх, захиалга өгөх, гэрээ хэлэлцээр байгуулах ажлаар энэ оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс 8 хоногийн хугацаатай Бүгд Найрамдах Хятад Ард Улсад албан томилолтоор ажиллуулсугай.

2. Цагдаагийн хурандаа С.Баасанжав, цагдаагийн хошууч Г.Баялагмаа нарт албан томилолтоор ажиллахад шаардагдах зардлыг батлагдсан төсвийн дагуу тооцож олгохыг Санхүү, аж ахуйн албаны дарга /цагдаагийн хурандаа Ж.Эрдэнэболд/-д зөвшөөрсүгэй.

3. Томилолтын үр дүнг илтгэх хуудсаар танилцуулж, түр хугацаагаар олгогдсон гадаад албан паспортыг Гадаад харилцааны хэлтэст буцаан хадгалуулахыг цагдаагийн хурандаа С.Баасанжав, цагдаагийн хошууч Г.Баялагмаа нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газрын дарга /цагдаагийн хурандаа Б.Бат-Өлзий/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА



С. БААТАРЖАВ

0901648